



ДУНДГОВЬ АЙМАГ  
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 15 өдөр

Дугаар А/83

Хажуу шинэ ус

Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх  
дархлаажуулалтын ажлыг зохион  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.8 дахь заалт, Улсын онцгой комиссын 2022 оны 02 дугаар тогтоол, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын А/191 дугаар тушаал, Аймгийн Засаг даргын А/358 тоот захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2022 оны 9 дүгээр сарын 15-ний эхлэн 20 хоногийн хугацаанд гоц халдварт шүлхий өвчний дархлаажуулалтад үхэр сүргийг бүрэн хамруулж ажиллахыг Угтаал Чандмань хоршоо Мал эмнэлэг үйлчилгээний нэгжийн малын эмч (Д.Амгалан)-д даалгасугай.

2. Малчид мал бүхий иргэдэд тов хүргэж, бэлэн байдлыг хангуулж ажиллахыг Ажирхай багийн Засаг дарга (Б.Мөнхтөгөлдөр), Морьт багийн Засаг дарга (Г.Батчулуун), Хонгор багийн Засаг дарга (Б.Даваасүрэн) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Дархлаажуулалтын ажлыг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангаж, шуурхай үр дүнтэй хэрэгжүүлж, захирамжийн хэрэгжилтийг хангуулж тайлагнаж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч (А.Бямбадорж)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ө.МӨНХ-АМГАЛАН

482201083